



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/194

Улаанбаатар хот

**Нийслэлийн Эрүүл мэндийн
газрын эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 2,328,055 /Хоёр сая гурван зуун хорин найман мянга тавин таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 2 нэр төрлийн 274,987 /Хоёр зуун далан дөрвөн мянга есөн зуун наян долоон/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 8 нэр төрлийн 2,053,068 /Хоёр сая тавин гурван мянга жаран найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.


3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /Н.Раднаасэд/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.ОДНАСАН

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 05 сарын
07 өдрийн АН дугаар тушаалын хавсралт



Актлах эргэлтийн бус хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Эрүүл мэндийн газар

№	Тавилга эд хогшлын нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	Байгууллагын үнийн санал	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	МСНН 200 сандал	8	ш	2	73,900.00	147,800	39,413	108,387	эвдэрсэн	актлах	устгэх
2	Сандал	17	ш	1	127,187	127,187	127,187	-	эвдэрсэн	актлах	устгэх
3	OASIS BR 81H сандал /дарга/	10	ш	1	328,040.00	328,040	328,040	-	эвдэрсэн	актлах	татах
4	Компьютерийн ширээ	17	ш	1	201,884.00	201,884	201,884	-	эвдэрсэн	актлах	татах
Тавилга, эд хогшлын дүн				5		804,911	696,524	108,387			
5	Дэлгэц холбогч	5	ш	1	165,000.00	165,000	71,500	93,500	эвдэрсэн	актлах	татах
6	Принтер 1102	6	ш	1	169,900.00	169,900	169,900	-	эвдэрсэн	актлах	татах
7	Принтер SCX-4300	9	ш	1	253,000.00	253,000	253,000	-	эвдэрсэн	актлах	татах
8	Принтер samsung 3405	6	ш	1	229,900.00	229,900	229,900	-	эвдэрсэн	актлах	татах
9	Принтер HP 1020	12	ш	1	155,344.00	155,344	155,344	-	эвдэрсэн	актлах	татах
10	Цаг бүртгэлийн төхөөрөмж	5	ш	1	550,000.00	550,000	550,000	-	эвдэрсэн	актлах	татах
Машин тоног төхөөрөмжийн дүн				6		1,523,144	1,429,644	93,500			
Нийт актлах хөрөнгийн дүн				11		2,328,055	2,126,168	201,887			
Үүнээс: Худалдах хөрөнгө											
Актлах хөрөнгө						274,987	166,600	108,387			

Татан төвлөрүүлэх хөрөнгө	2,053,068	1,959,568	93,500			
Худалдсанаас олох орлого						
НӨХГ-т төвлөрүүлэх /30 %/						